


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны 37 дугаар тэмдэглэлд:

“Ү1.2. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээрийн санхүүжилтээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжүүлж байгаа газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1) гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалттай холбоотой асуудлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажлын сонгон шалгаруулалтад оролцогчийн санхүүгийн саналыг тус үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан дүнд багтаах хэлцэл хийж танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР